

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



У.ОТГОНБАЯР

2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байгаа болно. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

1.Үндэсний их баяр наадам нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр" билээ¹. Монголчуудын үндэсний бахархлыг бадрааж, нүүдлийн соёл иргэншлийг дэлхий дахинаа сурталчилдаг Үндэсний их баяр наадам бол монгол түмний үндэсний ижилсэл-ондоошлын ухамсарт гүн нөлөөтэй чухал үнэт зүйл, арга хэмжээ юм. Тиймээс Монгол Улсын түүхийн бүхий л цаг хугацаанд монголчуудын үндэсний ухамсрыг сэргээх үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэсэн байдаг. Үндэсний их баяр наадмыг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай хуулиар тусгайлан зохицуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван хоёрдугаар зүйлийн 4-т "Монголын нэгдсэн тулгар төрийн уламжлалт Их цагаан туг нь Монгол Улсын төрийн хүндэтгэлийн бэлгэдэл мөн" гэж заасан бөгөөд Үндэсний их баяр наадмын нээлтээр Төрийн тугийг улсын баяр наадмын талбайд хүндэтгэн залж баяр наадмыг эхлүүлдэг. Тиймээс наадам бол Монгол Улсын төрийн хүндэтгэлийн ёслол юм. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1-т "Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн" гэж заасанчлан Үндэсний их баяр наадмыг Монгол Улсын Ерөнхийлөгч нээж үг хэлдэг. Баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагааг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу зохицуулж, Монголын ард түмний төрт ёс, түүхэн уламжлалыг хадгалж ирсэн.

Ийнхүү Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний

¹ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт

уламжлалт үндэсний их баяр наадмын нэг хэсэг нь үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёл бүхий хурдан морины уралдаан байдаг.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Үндэсний хурдан морины уралдааныг монгол үүлдрийн адууны стандартад нийцсэн морийг азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн зургаан насны ангиллаар зохион байгуулна.” гэж заасан бөгөөд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2025 оны С/31 дүгээр тушаалаар “Хурдан моринд тавих ерөнхий шаардлага” буюу MNS4099:2025 стандартаар хурдан морины сэрвээний өндрийн дээд хэмжээг тогтоож, Үндэсний их баяр наадам, шигшмэл хурдан морьдын “Их Хурд” уралдаан болон хурдан морины бүсийн уралдаан, аймаг, сумдын хурдан морины уралдаан зохион байгуулахад тус стандартыг мөрдөхөөр заасан. Мөн энэ тушаалаар баталсан Монгол үүлдэр, омгийн адуу стандарт /MNS4099:2025/-аар Монгол морьдын үүлдэрлэг байдал буюу гадаад шинжийг нь тогтоосон байна.

Үндэсний их баяр наадам, шигшмэл хурдан морьдын “Их Хурд” уралдаан болон хурдан морины бүсийн уралдаан, аймаг, сумдын хурдан морины уралдаанд дээрх стандартад нийцсэн адууг уралдуулах бөгөөд монгол эрлийз морьдыг сэрвээний өндөр, үүлдэрлэг байдал буюу гадаад шинжээр нь ялгаварлаж хурдан морины уралдаанд оролцуулахыг хориглосон шийдвэр нь маргаан дагуулсаар байдаг.

Мөн сэрвээний өндөр, монгол морины үүлдэрлэг байдал зэргийг үндэслэн морийг хурдан морины уралдааны бүртгэлд бүртгээгүй, уралдуулахаас хассан зэрэг нь тодорхойгүй, ил тод байдаггүй учраас олон уяачдын хөдөлмөр, хөрөнгийг үнэгүйдүүлж байна гэж үзэхээр байна.

2.Монгол Улсад ирж буй жуулчдын дийлэнх нь монголын соёлын өв болох монгол наадам (үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харваа) үзэхээр Монгол Улсыг зорин ирдэг учир Үндэсний их баяр наадам бол монгол түмний үндэсний ижилсэл-ондоошлын ухамсарт гүн нөлөөтэй чухал үнэт зүйл, арга хэмжээ болохыг дэлхий нийтэд таниулах чухал арга хэмжээ юм. Иймээс үндэсний морины уралдаан маань жуулчдыг татах нэг хөшүүрэг мөн тул аялал жуулчлалын бодлогтой нягт уялдаатай байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 4.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” гэж, 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж тус тус заасан.

Тус хөгжлийн бодлогын хүрээнд “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн байх” зорилтыг дэвшүүлж, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.47-д “...аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ” гэж заасан.

Ийнхүү олон улсын аялал жуучлалыг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий нэг чухал арга хэмжээ нь үндэсний өв соёл болох хурдан морины уралдаан гэж үзэж, уг хуулийн төслийг боловсруулна.

Манай орны эрс тэс цаг агаарын байдал болон өвлийн аялал жуулчлал хөгжөөгүй зэрэг нь өвлийн улиралд ирэх жуулчдын тоог бага байхад нөлөөлдөг учир өвлийн морин уралдаан зохион байгуулах арга хэмжээ нь бага боловч үр дүнгээ өгөх болно гэж найдаж байна.

3.Түүнчлэн хурдан морины уралдааныг дагаж унаач хүүхдийн эрхийн асуудал зайлшгүй хөндөгддөг. Судалгаанаас үзэхэд 2025 онд 343 хүүхэд мориноос унаж, 50 хүүхэд даатгалын нөхөн төлбөр авч байсан байна.

Хэдийгээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолоор жил бүрийн арваннэгдүгээр сарын 1-ээс тавдугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 хүртэлх насны хүүхдээр (энэ заалтад Засгийн газрын 2025 оны 41 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон) хурдан морь унуулахыг хориглосон боловч 2022 оны Сар шинийн баярын өдрүүдэд 7 аймагт хурдан морины бэсрэг болон бооцоот уралдаан зохион байгуулсан тухай Хүний эрхийн үндэсний комисс мэдээлсэн бөгөөд 2022 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр Архангай аймгийн Ихтамир сумын Элстэй гэх газар хурдан морины уралдаанд бэлдэж байсан 12 настай эрэгтэй хүүхэд мөсөн дээр унаж, моринд өшиглүүлэн дунд чөмгөө хугалсан тохиолдол гарч байжээ. Өөрөөр хэлбэл хуулиар зохицуулагдаагүй цаг хугацаанд далд хэлбэрээр, хараа хяналтгүй зохион байгуулсан гэж үзэж болно.

Иймд дээр дурдсан бодлогын баримт бичигт туссан зорилтыг хэрэгжүүлэх, унаач хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр өв соёл, түүхэн уламжлалаа тээж үлдэх, соёл, уламжлалаараа жуулчдыг татаж, аялал жуучлалыг нэмэгдүүлэх шаардлага байгаагаас гадна хурдан морь эзэмшигч, уяачдад аль ч улиралд морио уралдуулах, Үндэсний баяр наадамд уралдуулж чаддаггүй морио уралдуулах бололцоог бий болгох, цаашид олон улсын жишигт нийцсэн морин тойруулга байгуулж, бооцоот морин уралдаан зохион байгуулах асуудлын эрх зүйн орчныг бий болгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

4.Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 73 дугаар тогтоолоор Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтийг хангуулах, монгол малын генетик нөөцийг хамгаалах, ашиглалтын тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Энэ нь:

1/малын генетик нөөцийн төлөв байдлыг үндэсний хэмжээнд шинэчлэн тодорхойлох ажлыг зохион байгуулж, уг арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулах, цаашид хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг зохион байгуулах;

2/“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д заасны дагуу бүс нутгийн онцлогт тохирсон цөм сүргийг үржүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, дэмжин хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/үржлийн адуу, түүний үр, хөврөлийг импортлох тоо хэмжээг 2026-2036 он хүртэлх хугацаанд тэг /"0"/ хувьтай тэнцүү байхаар тогтоох;

4/адуун сүргийн тархац, үүлдэрлэг байдлыг бүс нутгаар гаргах, үржлийн адуунд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх, үндэсний хэмжээний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, адуу судлал, төрөлжилт, ашиглалтыг нэгдсэн бодлогоор хөгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх асуудал байсан.

1.2.Практик шаардлага

Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан үндэсний хурдан морины уралдааны төрөл, түүний хэв шинжийг баяжуулах, уралдааныг зохион байгуулах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох шаардлага үүссэнийг илтгэх хэд хэдэн практик шаардлага үүссэн байна. Үүнд:

1.Монголчуудын баяр наадам, хурим найр, баяр ёслолын үеэр заавал зохион байгуулдаг уламжлалт наадмыг соёлын өв юм. Эрт үеэс мал аж ахуй хөдөлмөрийнх нь хамгийн гол салбар болсон нүүдэлчдийн уудам талын малчны амьдралыг хүлэг морьгүйгээр сэтгэшгүй байдаг монголчуудын хувьд хурдан морины уралдаан маш эртний үүсэлтэй уламжлалт наадам юм.

Монголчууд таван хошуу малаа маллан өсгөх, адуулах, хариулах, өвс бэлчээр сонгох талаар бүхэл бүтэн мэдлэг ухааныг буй болгосны дотор сайн морь, хурдан хүлгийг шинжин таних, морь уяж сойх арга, мэдлэгийн тогтолцоог бүрдүүлэн морь уралдуулж наадам хийх журам ёсыг тогтоон бий болгосон юм. Ийнхүү хурдан морин уралдаан нь амьдралын хэрэгцээ баяр наадмын гоёл цэнгээний шаардлагаар үүссэн монгол хүний хамгийн дуртай цэнгэл болсон байна.

Монголчууд эртнээс морийг эрхэмлэн дээдлэн, шүтэж ирсэн ард түмэн билээ. Учир нь өдөр тутмын уналга ачлагаас эхлэн, дэлхийг байлдан дагуулсан бүхий л үеийг монгол морьгүйгээр төсөөлөхгүй байхын аргагүй. Хүний хөл хүрч үзээгүй газрын хэвлийд туурайн мөрөө үлдээсэн монгол морио эдүгээ бид төрийн сүлдэндээ дүрслэн, дэл сүүлээр нь үндэсний хөгжим урлаад зогсохгүй хурдан морины уралдааныг үндэсний баяр наадмын нэг хэсэг болгон баяр наадмаа ёслол төгөлдөр тэмдэглэсээр байна.

2.Манай улс нүүдлийн соёл, уламжлалаараа жуулчдыг татаж, орлого олох эрмэлзлээ улам бүр өргөжүүлэн Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан үйл ажиллагааг төлөвлөх, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд үндэсний хурдан морины уралдаан чухал ач холбогдолтой тул түүнийг орлого олох хэлбэрээр хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

3.Морины эзэн, уяачид Үндэсний их баяр наадам, бүсийн хурдан морины уралдаанаас гадна бусад улиралд морио уралдуулах, орлого олох, мөн морины уралдааныг олон ангиллаар зохион байгуулах, цаашлаад морин тойруулга байгуулж, бооцоот морины уралдаан зохион байгуулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

4. Монгол улсад Монгол адууны онцлогоос шалтгаалан Үндэсний их баяр наадмын тухай хуульд хурдан морины уралдаанд уралдах морийг найм, түүнээс дээш насны хүүхэд унахаар хуульчлан заасан байдаг. Харин Монгол Улсын Засгийн

Газрын шийдвэрээр 2019 оноос жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1 хүртэл хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 хүртэлх насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосон. Засгийн газраас баталсан 2017 оны морин уралдааны хуваарьт өвлийн уралдаанууд багтсанаас болж ТББ-ууд шүүхэд хандаж, улмаар 2017 онд өвлийн морин уралдааныг зохион байгуулахыг шүүхийн шийдвэр гартал түдгэлзүүлэх захирамж гарчээ. Энэ үеэр Засгийн газрын шийдвэрийн дагуу "Дүнжингарав 2017" хурдан морины өвлийн уралдаан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж шүүхийн шийдвэрийг үл ойшоосон хэмээн шүүмжлэгдэж байв.

Ийнхүү Засгийн газрын шийдвэрээр өвлийн хурдан морины уралдааныг хориглосноос хойших хугацаанд энэ уралдаан далд нууц хэлбэрт шилжиж тэр хэмжээгээр төрийн байгууллагаас тавих хяналт суларснаас болж хүүхдийн эрх зөрчигдөх явдал нээлттэй үеийнхээс улам ихсэж байна. Энэ хугацаанд хүүхдийн эрх улам бүр зөрчигдөхөөс гадна өвлийн морин уралдаан манай хилийн урд зүгт буюу БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны хил дагуу аймгуудад шилжиж зохион байгуулагддаг боллоо. Ийнхүү манай уяачид өөрсдийн морьд унаач хүүхдүүдээ авч хил гаран уралдаан тэмцээнд оролцох болжээ. Тухайлбал;

Засгийн газрын тогтоолыг зөрчин өнөөдрийн байдлаар Дорнод аймагт 1, Төв аймагт 7, Ховд аймагт 1, Сонгинохайрхан, Налайх дүүрэгт тус бүр 1 удаа хурдан морины уралдаан нийт 11 удаа нууцаар зохион байгуулагдаж байсан байна.

Ийнхүү хориглосноор далд хэлбэрт шилжиж, манай улсын эд хөрөнгө, мөнгө урд зүг рүү шилжих, монгол морьд арилжаалагдаж, түүний удмын ген гадны морьдын гентэй холилдох, улмаар эрлийзжиж монгол адууны ген устах аюул бий болох эрсдэл өндөр боллоо.

Жил бүр хурдан морины уралдааны үед хүүхдүүд мориноос унаж гэмтэх, амь насаа алдах тохиолдолууд гарч, түүнээс болж хүний эрхийн болон хүүхдийн байгууллагууд уралдааны журмыг өөрчлүүлэх, энэ асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал, санаачилгууд гарч байгаа ч дээрх хууль зүйн болоод практик шаардлагын дагуу хаврын хурдан морины хуралдааны эрхийг нээж түүнийг зохион байгуулах эрх зүйн үндсийг сайжруулсан хуулийг батлах шаардлагатай байна. Хориглох биш уг асуудлын шалтгаан нөхцөл чухам юу болох үндсийг тодорхойлж, түүнийг арилгахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

1.Хаврын морин уралдааны эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Үндэсний их баяр наадын тухай хуульд хаврын хурдан морины уралдаан гэсэн шинэ зүйл нэмэлтээр оруулж нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн хэлбэрээр боловсруулна:

Хуулийн төслөөр дараах асуудлыг зохицуулахаар тусгана:

Хаврын хурдан морины уралдааныг аймаг, нийслэлд жил бүр хаврын тэргүүн сарын шинийн 15-ны, эсвэл түүний доторх аль нэг өдөр цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулж болно. Уралдааны товыг Засгийн газрын шийдвэрээр тогтоохоор төсөл боловсруулах болно.

Хаврын хурдан морины уралдаан зохион байгуулахдаа дараах шаардлагыг хангасан байх: Энэ шаардлагад дараах асуудал багтаж байхаар томьёолох юм.

1.морь уралдуулах зурвасыг тусгайлан засаж, аюулгүй байдлыг бүрэн хангаж, уралдуулах;

2.уралдааны морийг 14 болон түүнээс дээш насны уралдаанч хүн унаж уралдуулах;

3.уралдаанч хүнийг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13.2-т зааснаас өөр дулаанаа хадгалдаг, салхи, ус, цас нэвтрүүлдэггүй хувцас, осол, гэмтлээс хамгаалах хэрэгсэл өмсгөж уралдуулах бөгөөд эдгээр хувцас хэрэгсэл нь сэрүүний улиралд тохирсон байх;

4.уралдаанч хүнийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан нэг жилийн ослын даатгалд заавал даатгуулсан байх;

5.морины уяач нь уралдааны морь уралдаанч хүнтэй болон түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулсан байх;

6.хүн, мал эмнэлгийн тусламжийн хэсгийг хаврын хурдан морины уралдааны замд өртөөчлөн байрлуулж, тусламж үйлчилгээ үзүүлэх бэлтгэлийг хангасан байх;

7.аюулгүй байдлыг хангах, хэв журмыг сахиулах бэлтгэл ажлыг хангасан байх.

Хаврын хурдан морины уралдаанд азарга, их нас, соёолон насны морьдыг уралдуулна. Уралдаж байгаа морины насны ангиллаас хамаарч азарга, соёолон насны морьд 16-17 километр, их насны морьд 18-19 километр замыг туулж уралдах зохицуулалт хийнэ.

Хаврын хурдан морины уралдааныг зохион байгуулах бэлтгэл, аюулгүй байдлыг хангах, хэрэгжилтийг хянах журмыг Засгийн газраас баталж мөрдүүлэх зохицуулалт хийх юм.

Энэ хуулийн төсөлд заасан шаардлагын нэг болох дулаанаа хадгалдаг, хувцас хэрэглэлийн стандартыг хүүхдийн эрхийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үндэсний морин уралдаан, уяачдын хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллагын саналыг үндэслэн боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлахаар тусгах.

Энэхүү хамгаалалтын хувцас хэрэгсэл нь зуны улиралд хэрэглэдэг хамгаалалтын хувцас хэрэгсэлээс өөр стандарттай байхаар зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засгийн үр дагавар, тэдгээрийн шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно гэж төсөл санаачлагчийн хувьд үзэж байна:

- Морины эзэн, уяачид Үндэсний их баяр наадам, бүсийн хурдан морины уралдаанаас гадна бусад улиралд морио уралдуулах, орлого олох, мөн морины уралдааныг олон ангиллаар зохион байгуулах боломжтой болно.

- Үндэсний хурдан морины уралдаанд уралдах морийг 8, түүнээс дээш насны хүүхэд унахаар хуульчилсан байдаг бол, харин хаврын морин уралдааны унаач хүний насыг 14 насанд хүрсэн хүн байхаар тогтоож, стандартын хамгаалалтын хувцас, хэрэглэл хэрэглэх тул эрх зөрчих асуудал багасах бөгөөд моринд гарамгай хүмүүст шинээр ажлын байр бий болох давуу талтай болно.

- Монголын залуу малчид морь дагаж, монгол өв соёлоо тээн, хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байдаг тул тэдний урам зоригийг сэргээх, залуу малчдын тоог нэмэгдүүлэх том хөшүүрэг болох юм. Улмаар морин спортыг олон нийтэд сурталчлах, хөгжүүлэх, морь шинжиж мэддэг хүмүүс морь худалдан авах зэргээр чөлөөт цагаа сонирхолтой өнгөрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

- Уралдаан үзэгч нь бүсийн болон улсын хурдан морины уралдаангүй цагт ч морин уралдааныг үзэхээр очих, эсхүл өргөн нэвтрүүлгээр дамжуулан үзэж сонирхох боломжтой болох бөгөөд дотоодын иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх, гадаадын жуулчид зорьж очих үзэх зэрэг ач холбогдолтой байна.

Түүнчлэн монголчуудын үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг бэхжүүлэх, эв нэгдлийг хангахад чухал ач холбогдолтой болно.

Үндэсний морин уралдааны нэг төрлийн эрх зүйн үндсийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгаснаар морин уралдаан нь үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүхэн уламжлалыг бэхжүүлэх, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн асар өргөн агуулгатай тул түүний нэг хэсэг болох үндэсний хурдан морины уралдааны төрөл хэлбэрийг өөрчлөн нэмэгдүүлэх нь цаашид морин спорт хөгжиж, морин тойруулга бий болж тэр хэмжээгээр энэ спорт эдийн засгийн эргэлтэнд орж, эдийн засгийг солонгоруулах төрийн бодлогод чухал нөлөө үзүүлэх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах хүрээнд уг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой бүрнээ нийцэж байгаа бөгөөд хуулийн төслийг дагаж Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах болно.

---oOo---